

**Манж, Богд хаант Монгол улсын үеийн газрын зургийн уламжлал,  
түүнд газрын биетийг тэмдэглэсэн нь**

*Ж. Нарангарав (МУИС)  
Э. Равдан (МУИС)*

**Түлхүүр үгс:** газрын зураг, дэвсгэр нэр, газрын (байгалийн) биет, уламжлал, тэмдэглэх, үйлдэх

Энэхүү өгүүллийн гол зорилго нь Манж Богд хаант Монгол улсын үеийн газрын зургийн уламжлал, түүний өвөрмөц онцлог, байгалийн биетийг заасан дэвсгэр нэрийн тэмдэглээг тогтооход оршино.

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа хүрээлэн буй орчин, эд агуурс, байгалийн биетийг өөр хооронд нь ялган нэрлэж иржээ. Байгалийн биетийг (уул, ус, гол, горхи гэх мэт) тэмдэглэх, газрын зураг үйлдэх болсон нь чулуун зэвсгийн үеэс эхлэлтэй бөгөөд тэр үеийн зураг үйлдэж байсан эд юм нь элс, чулуу, зомгол байсан бөгөөд арай хожуу үеийх нь ангийн арьс, хад, шавар зэрэг байжээ. (World book, v.13, 177-185), (Britanica, v. 23, 473-494) Түүн дээр тэмдэглэсэн байгалийн биетийн дүрслэл нь (уул, ус г.м.) газрын зургийн үүдэл болой. Түүнийг өөрөөр сүг зураг гэх нь ч бий. Монгол улс нь хадны сүг зургаар нэн баялаг бөлгөө.

Хятадын үндэсний түүх буюу Мян-сы-люй (1934 хятад хэлээр) сурвалжаас үзвэл монголчууд газрын зураг хийж хэрэглэж байсан тухай мэдээ МЭӨ III зуунд буюу Хүннү гүрний үед холбогдохоор ажээ. Энэ нь эртний монголчуудын соёл, оюун сэтгэцийн хөгжил хэр өндөр байсныг нотлон харуулж байна. (Гончигдорж, 1970) Түүнчлэн Монголын их эзэнт гүрний үед хүмүүсийн газарзүйн мэдлэг, ойлголтонд эргэлтийн чанартай өөрчлөлт гарсны үндсэн дээр дэлхийн анхны зураг зохиогдсон тухай Японы Масаки Сугияма нотолжээ. Энэ тухай акад. Ш. Бира бүтээлдээ дурджээ. (Бира, 2006, 80-р талаас үзнэ үү.)

1691 онд Ар Монгол Манжийн эрхшээлд орж, тусгаар тогтнолоо алдсан үеэс манжууд засаг захиргааны шинэ нэгжийг (аймаг, хошуу г.м.) нэвтрүүлэн 1730-аад оноос аймаг, хошуу, шавь зэргийн хил хязгаарыг тогтоон газрын зурагт тэмдэглэх


ажлыг эхлүүлжээ. Тийнхүү газрын зургийг манжийн элч төлөөлөгч, алба хаагчдын удирдлагаар монголчууд бараг 1924 дуустал шинээр үйлдэх, боловсронгуй болгох албыг залгуулж байсан байна. Монгол улсын тэр үеийн нийт зургийн чанар нь, В.А. Казакевичийн зөв зохистой тэмдэглэснээр: “зүүнээс баруун тийш хандах тутам муудсан байна. Тэр нь газар ашиглах хуваарилалт, аймаг, хошууны хил хязгаар тогтоох бүх асуудал, тэр дундаа буулгасан зургууд нь хүртэл манжижсан түшмэдүүдийн мэдэлд байсан, нөгөөтэйгүүр манж хятадын нөлөө юуны өмнө нутгийн зүүн хэсэгт илүү байснаа баруун зүг рүү багасаж байсантай холбоотой.” ажээ. (ДТМГНН, 2005, 34-р талаас үзнэ үү) . Хэдий тийм боловч энэ нь монголчуудын соёл, түүхийн нандин өвийн нэг мөнөөс мөн бөгөөд түүнийг анхааралтай судлах цаг үе нь нэгэнт болжээ хэмээн бид үзэв.

Судалгааг бид МУИС-ийн “Нэр судлал”-ын төвийн цуглуулгад байгаа Манж, Богд хаант улсын үеийн Халх 4 аймгийн 89 хошуу, Ховдын хязгаар, 10 шавь, 24 өртөө, харуул зэргийн давхардсан тоогоор нийт 260 гаруй газрын зургийн үндсэн дээр хийж гүйцэтгэв. Тэгэхдээ газрын зургийн чанар, хошуудын зургийн олон хувилбар бүхий Сэцэн Хан аймгийн хошуудын зургийг гол судлагдахуунаа болгов.

Монгол газар нутгийн нэрийг судласан гадаад, дотоодын эрдэмтдийн цөөнгүй бүтээл бий. Тоймыг (Равдан, 2004, 19-30-р тал)-аас дэлгэрэнгүй үзнэ үү. Харин чухамдаа монгол газрын зургийн үүсэл, хөгжил, үйлдэж байсан уламжлал, түүнд газар нутгийн нэр, тэр дундаа дэвсгэр нэрийг хэрхэн тэмдэглэдэг байсан тухай судалгаа хомс байна. Бидэнд мэдэгдэж байгаа энэ талын судалгааны заримаас нь дурдвал: Б. Я Владимирцов<sup>1</sup> (Владимирцов, 1911), В.А. Казакевич (Казакевич, 1934), Joseph Kler (Kler, 1956), Hedin Sven (Sven, 1969), W. Heissig (1978-1981), Б. Гончигдорж (Гончигдорж, 1970), Д. Эрдэнэцэцэг (Эрдэнэцэцэг, 2000), Ц.Шагдарсүрэн (Шагдарсүрэн, 1977), Н. Futaki, К. Akira (Futaki, 2005) зэрэг өгүүлэл, газрын зургийн цомог болно. Тэдгээрээс Манж, Богд хаант Монгол улсын үеийн газрын зургийг Б.Я. Владимирцов, В. Хайссиг, Х. Футаки нар их, бага хэмжээгээр хэвлэн нийтэлж шинжилгээ судалгааны эргэлтэнд оруулжээ. Үлдсэн бүтээлүүдэд монгол газрын зургийн уламжлалын тухай аль нэгэн байдлаар өгүүлсэн байна. Энэхүү бүтээлүүдийн тоймыг (Равдан, 2004 үзнэ үү.) Бид энэ удаа монгол зургийг үйлдэж байсан уламжлалт аргатай шууд холбоотой хоёр эрдэмтний бүтээлийг дэлгэрэнгүй авч үзье.

Б. Гончигдорж “Монголчуудын газарзүйн зургийн түүхийн зарим асуудалд” өгүүлэлдээ Монгол газрын зургийг үйлдэж байсан үндсэн хоёр аргын тухай анх өгүүлжээ. Тэдгээрийн нэгийн тухай тэрбээр өгүүлэхдээ: “...Эхлээд хошууны нутгийн дунд хирд хүрд босгож түүнийхээ дугуйг хоног (градус) гарган хуваана. Зурхайн ухаанд тойргийг 360 хоног (градус) болгон хуваадаг. Тэгээд хилийн нэг овоог босгохын тулд хүрднийхээ хоногийн нэг хуваарийн дагуу газар хэмжигч хүнээ явуулан төчнөөн хэмжээний газар яваад овоо босго гэнэ. Энэ мэтчилэн хилийн бүх овоодыг босгоно” гэжээ. (Гончигдорж, 1970, 60-р тал)

<sup>1</sup> Б. Владимирцов, В. Казакевич, Ж. Клер, В. Хайссиг нарын бүтээлийг бид (ДТМГНН, 2005) товхимолд орос, герман, францаас монголоор хөрвүүлэн тавьсан болно.



Зураг 1

Б. Гончигдоржийн заасан энэхүү аргаар үйлдсэн зураг Сэцэн Хан аймгийн нийт хошуудын нутгийн зурагт 3 байна. Үүнд: 1. Эрх засгийн хошууны газар нутгийн зураг. 1847 онд, 2. Дайчин засгийн хошууны газар нутгийн зураг. Төр Гэрэлтийн XXVII он буюу 1847 онд, 3. Саруул гүний хошууны газар нутгийн зураг. Төр гэрэлтийн XXIX он буюу 1849 онд тус тус үйлдсэн байна. Тиймээс энэ аргаар зураг үйлдэх нь харьцангуй түгээмэл биш ажээ. Харин Б. Гончигдорж дээрх өгүүлэлд тэмдэглэсэн, хожим нь Ц. Шагдарсүрэн дэлгэрэнгүй өгүүлсэн газрын зураг үйлдэж байсан монголчуудын хоёр дахь арга нь нэлээн түгээмэл учраас түүнийг гол арга хэмээн нэрлэж болно. Энэхүү аргын тухай Ц. Шагдарсүрэн өгүүлэхдээ: "...Монголчууд газрын зураг үйлдэхдээ зургийн суурь болгож тойрог татаад, тойргоо

Дөрвөн зүг	Найман өнцөг
Найман өнгө	Дөрвөн зовхи


гэж 24 хуваагаад энэ 24 хуваарь тус бүрийг ( . ) завсар хэмээж бүгд 48 болгодог байжээ. Иймд нэг хуваарь нь 7.5 хэмтэй тэнцүү юм байна. Эдгээр 24 хуваарь нь тус бүртээ тусгай нэртэй. Зургийн суурь болгосон тойрогт дээрх 24 хуваарь, тэдгээрийн завсрын хамт нийт 48 хуваариа тогтсон дэс дараатайгаар нар зөв тойруулан байрлуулахдаа дөрвөн мөчлөг болгож хуваана. Ийнхүү зургийн сууриа бэлтгэсний дараа тухайн газар нутгийн зургийг үйлдэх бөгөөд гол төлөв өмнө буюу морин зүгээс эхлэн нутгийн хил хязгаарын овоо дээс бүрийн хоорондын зайг нарийн хэмжиж 48 чиглэлдээ таацуулан эхний овооноос нар зөв эргүүлэн, үргэлжлүүлэн зурсаар мөнөөх л морин зүгтэйгээ уулзуулан дуусгадаг байжээ.

Газрын зургийг үйлдэхдээ их төлөв чиг цардмал цагаан даавуу буюу муутуу цаасан дээр өнгө ялган үйлддэг байсан бөгөөд тийнхүү өнгө ялгахдаа хэн хүн дур дураараа өнгө будаг тавьдаггүй, тогтсон дүрмийн дагуу зурдаг байсан ба зураг нь зөвхөн хил хязгаарыг татсан цулгай зураг байгаагүй бөгөөд нутгийн уул, ус, гол мөрөн, нуур, шанд, худаг, булаг, сүм хийд, зам харгуй зэргийг харуулсан байдаг бөгөөд зарим зурагт голын урт, урсгалын чиг, уулын өндөр, нуурын тойргийн урт зэргийг маш нарийн заасан байдаг" гэжээ. (Шагдарсүрэн, 2003, 10-р талаас үзнэ үү). Энэхүү аргаар

Манж, Богд хаант Монгол улсын үеийн нийт газар нутгийн зургийн дийлэнх хэсэг буюу 80 гаруй хувийг үйлдсэн байна.

Газрын зураг үйлдэж байсан дээрх хоёр аргаас гадна гуравдахь арга байсныг бид судалгаагаар тогтоов. Эл аргаар газрын зургийг үйлдэхдээ хошууны нутагт төв цэгийг урьдчилан тогтоож (Төв цэг нь хошуу, засаг ноёны өргөө, алба, тамгын газар байж болно.) түүнээсээ бүх нутгийг нарны эргэлтээр тойруулан газрын гадаргаас дээш гарсан биет, тухайлбал уул, толгой гэх мэтийн оройг төв цэг рүүгээ хандуулан үйлдсэн байна. Газрын биетийн нэрийг мөн төв тийш нь хандуулан хаджээ. Эл аргаар, жишээлбэл Халхын Сэцэн Хан аймгийн Сэцэн вангийн хошууны зургийг үйлдсэн байна. Зураг 2-ыг үзнэ үү. Зургаас дараах зүйлийг ажиглаж болно. Үүнд:

- Зургийн дунд “ᠠᠨᠠᠭᠤ ᠠᠨᠠᠭᠤ” гэсэн байх ба түүний хажууд “ᠠᠨᠠᠭᠤ ᠠᠨᠠᠭᠤ” хэмээн тэмдэглэжээ.
- Газрын биетийн оноосон нэрийг бичихдээ толгойг нь төв хэсэг рүү хандуулсан байна.
- Нутгийн хилийн шугамыг маш нарийн хийсэн бөгөөд уг хошуутай хиллэсэн аймаг, хошуунаас зааглаж буй газрын биет бүрийг алхам тутамд тэмдэглэсэн байдал зэрэг болно.



Зураг 2. Халхын Сэцэн Хан аймгийн Сэцэн вангийн хошууны газрын зураг

Энэхүү аргаар үйлдсэн зураг цөөвтөр таарч байгаа хэдий ч үйлдсэн арга нь маш өвөрмөц, анхаарал татахуйц ажээ.

Аливаа газрын зурагт тэмдэглэдэг Олон улсын үндсэн үзүүлэлтийн стандарт бий. (Салишеев, 1982). Тэрхүү стандарт Сэцэн Хан аймгийн нийт газрын зурагт

бүхэлдээ тусчээ гэж үзэхээр байна. Нийт зурагт дараах үзүүлэлтүүдийг тэмдэглэжээ. Үүнд:

- хошууны нэр;
- үйлдсэн он;
- газрын гадаргын тэмдэглээ ;
- гадаргын усны тэмдэглээ ;
- суурин газрын тэмдэглээ ;
- зам харгуйн тэмдэглээ;
- ургамал бүрхэвчийн тэмдэглээ ;
- газрын биетийн нэрийн тэмдэглээ ;
- Хил хязгаарыг заасан зэрэг болно.

Бид өмнө газрын зургийг үйлдэж байсан уламжлалт гурван арга, зургийн үндсэн үзүүлэлтийн тухай өгүүллээ. Одоо газрын биетийн нэрийн тэмдэглээний тухай өгүүлье.


Аливаад оноосон нэрд бид дараах үзэл баримтлалын үүднээс хандаж байна. Үүнд:

- бүтцийн хувьд дэлхийн нийт хэл-соёлд хоёр бүтээвэр буюу утга илэрхийлсэн хоёр (уг юм, үзэгдлийн нэрийтгэл буюу дэвсгэр нэр, түүнд оноосон нэр ) хэсгээс бүрдэл болно. Дэвсгэр нэр нь ахуйн хэрэглээнд харилцагч хүмүүс хүн, газар орны гэх мэтийн нэр хэмээн амьдралын туршлагаасаа мэддэг тул хураагдан оноосон нэрээр нь ойлголцох нь түгээмэл ажээ.
- Оноосон нэрийн утга, хэлбэр нь дэвсгэр нэрээс бүхэлдээ хамаардаг түгээмэл зүй тогтол дэлхийн нийт хэл-соёлд үйлчилдэг. Түүний наад захын жишээ нь монголчууд жалгынхаа нэрээр уул, усаа, эсвэл нохойны нэрээр хүнийг, хоол, ундны нэрээр хивсийг нэрлэдэггүй уламжлалтай болно.
- Дээрх олон хэл-соёлын түгээмэл зарчим нь олон үндэстний оноосон ба дэвсгэр нэрийн өвөрмөц онцлогийг үгүйсгэдэггүй ажээ. Үндэстэн бүрийн дэвсгэр болон оноосон нэрийн сан тэдний шашин шүтлэг, аж ахуйн зонхилох хэвшил, хэлний тогтолцооны хэв шинж зэрэг цөөнгүй хүчин зүйлээс хамаардаг. Бусад цөөнгүй шинж тэмдгийн талаар (Равдан, 2004 номоос дэлгэрэнгүй үзнэ үү.) Жишээлбэл, нүүдлийн аж ахуйн хэвшил бүхий Монгол оронд байгалийн биетийг заасан дэвсгэр нэрийн өв сан суурин соёл иргэншилтэй орныг бодвол хэдэн зуу дахин баян ажээ. Э. Равдангийн судалгаагаар эл төрлийн дэвсгэр нэр өнөөгийн монгол хэлэнд 400 орчим байна. Харамсалтай нь тэрхүү баян сан газрын зурагт бүрэн дүүрэн тусдаггүй ажээ.

Одоо Сэцэн Хан аймгийн хошуудын газрын зурагт орсон дэвсгэр нэрийн төрөл зүйл, тэмдэглээний онцлогийг доор дэлгэрэнгүй авч үзье. Сэцэн хан аймаг, түүний бүх хошууны газрын зурагт нийт 83 дэвсгэр нэр, түүнийг тодорхойлон ялгасан оноосон гишүүн нэр давтагдсан байдлаараа ойролцоогоор 2800 байна. Дээрх 83 дэвсгэр нэрийг газрын зурагт хэд хэдэн янзаар тэмдэглэсэн байна. Үүнд:

- дэвсгэр нэрийг үсэг болон дүрсээр хослон тэмдэглэсэн;
- дэвсгэр нэрийг дүрс буюу зургаар тэмдэглэсэн;
- дэвсгэр нэрийг зөвхөн үсгээр тэмдэглэсэн,
- дэвсгэр нэрийг тусгайлан заагаагүй болно.

Сэцэн Хан аймгийн нийт газрын зурагт дэвсгэр нэрийг ихэвчлэн үсэг болон дүрсээр хослон тэмдэглэжээ. Харин дэвсгэр нэрийг тэмдэглэлгүй, дүрс болон зургаар илэрхийлсэн тохиолдол 100 орчим оноосон нэрэнд таарлаа. Энэхүү байдлыг Сайн Ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны зургаар жишээ болгон үзүүлье. *Харгана, Хужирт, Хуягт, Заан, Мөст* зэрэг оноосон нэрийг үсгээр тэмдэглэж харин уул гэсэн дэвсгэр нэрийг нь модтой уулын дүрсээр заажээ. Дээрх нэрийг доор зурагт 11, 12, 13, 70, 84 тоогоор заав. Мөн зурагт Тэрх голын эхэнд *Урд Тэрхийн эх, Хойд Тэрхийн эх*, мөн *Хоёр Тэрхийн бэлчир* хэмээн тэмдэглэжээ. Энд Тэрх нь газрын ямар биет болохыг зургаар үзүүлсэн тул зургаас Тэрх нь “гол” гэдгийг хэн ч ойлгохоор байна. Ийм учир дэвсгэр нэрийг нь бичээгүй байж болно.



Зураг 3. Сайн Ноён Хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу

Дэвсгэр нэрийг зөвхөн үсгээр тэмдэглэсэн нь цөөн байна. Энэ нь гол төлөв тал газар, засаг ноёны суух газар зэргийн тэмдэглээнд ажиглагдаж байна. Жишээ нь: “*ᠬᠠᠷᠭᠠᠨᠠ*” “*ᠬᠤᠵᠢᠷᠲᠤ*” гэх мэт болно. Энэхүү онцлогийг түүнчлэн Халхын Сэцэн Хан аймгийн Сэцэн вангийн хошууны газрын зургаас ч харж болно. (Зураг 2-ыг үзнэ үү.)

Дэвсгэр нэрийн тэмдэглээний сүүлчийн хэв шинж буюу түүнийг тухайлан заагаагүй тохиолдол Манж, Богд хаант Монгол улсын үеийн нийт газрын зурагт цөөн ч гэсэн тааралдаж байна. Өөрөөр хэлбэл, зурагт газрын биетийг зөвхөн оноосон гишүүнээр нь тэмдэглээд дэвсгэр нэрийг нь орхисон тохиолдол юм. Тийм нэрсийг өндөр нарийвчлалтай газрын зургаас хайж, чухам газрын ямар биетийг нэрлэснийг

тогтоохоос өөр аргагүй болдог. Жишээлбэл, бид Сайн Ноён Хан аймгийн Өөлд Бишрэлт Бэйсийн хошууны зурагт дэвсгэр нэргүй тэмдэглэгдсэн Ямаат оноосон гишүүний дэвсгэр нэрийг Монгол орны 1:200000-ын масштаб бүхий газрын зургаас хайхад тэр нь :

- Ямаат уул
- Ямаатын даваа
- Ямаат гол
- Ямаатын булаг
- Ямаатын бургас зэрэг нэг хэсэг газрын ерөнхий нэр байв.

Дэвсгэр нэрийг газрын зурагт тэмдэглэлгүй орхисон нь тухайн хошууны зураг албан бус, орон нутгийн чанартай зураг байсан ч байж болно. Хэдийвээр тийм байсан ч газрын биетийн дэвсгэр нэрийг газрын зурагт заагаагүй тохиолдлыг зөв зохистой хэмээн үзэж болохгүй.

Сэцэн Хан аймгийн газрын зураг дахь 83 дэвсгэр нэрийг утгын дараах дөрвөн оронд хувааж болохоор байна. Үүнд:

- Газрын хотгор, гүдгэр гадаргууг заасан дэвсгэр нэр (39)
- Гидроним буюу усны сурвалжийг заасан дэвсгэр нэр (23)
- Фитоним буюу ургамлын зүйлийг заасан дэвсгэр нэр (5)
- Ойконим буюу суурин газрыг заасан дэвсгэр нэр (12) тус тус байна.

Бид дээрх нэрсийг Сэцэн Хан аймгийн хошуудын газрын зурагт хэрхэн туссан байдлыг Эрхэмсэг бэйсийн хошууны газар нутгийн зургаар жишээ болгон харуулая. Үүнд:

- Сэцэн Хан аймгийн чуулганы дарга, дөрвөн зэрэг тэмдэглэсэн, засаг улсын түшээ гүн Эрдэнэтогтоолын хошуу. Бүрэнт засагчийн III он, сарын шинийн гурванд буюу 1864 онд үйлдсэн;
- Хошууны нэр байхгүй. Бадруулт төрийн XVI он, өвлийн тэргүүн сарын шинийн есөнд буюу 1890 онд үйлдсэн ;
- Хошууны нэр байхгүй. Бадруулт төрийн XXXIII он, хаврын сүүл сарын шинийн хорин зургаанд буюу 1907 онд үйлдсэн.

Дээрх хошуу нь өөр өөр онд үйлдсэн гурван хувилбар зурагтай бөгөөд тэдгээр зурагт нийт 101 оноосон нэр тэмдэглэгдсэн байна. Дэвсгэр нэр 18.

Дэвсгэр нэр	1864	1890	1907
УУЛ			
НУУР			
БУЛАГ			
ТОЛГОЙ			
БҮРД			
ГОЛ			
ЗАМ			
ХАД			
ОВОО			

ЧУЛУУ			
УХАА			
СҮМ			
ХОШУУ			
ДАВАА			
МӨРӨН			
ГЭР			
АЛБАНЫ ГАЗАР			
МОД			

Эхний эгнээ буюу 1864 оны зурагт байгалийн биетийг нутгийн хойд этгээдээс харан дүрсэлж, гол болоод булгийг дээрээс нь харсан байдалтайгаар уртыг нь бичиж, уулын өндөр, хилийн овоог дугаарлан тусгайлан бичиж үйлджээ. Удаах эгнээ буюу 1890 оны зурагт газрын биетийг нутгийн өмнө талаас нь дүрслэн, нэрийг нь тусгайлан бичжээ. Гутгаар эгнээ буюу 1907 оны зургийг өмнөх оны (1890) зурагтай ижил үйлдсэн боловч уг оны зургийн нутаг дэвсгэрийн хэмжээ өөрчлөгдсөн байна.

Судалгаагаар бид дараах дүгнэлтэнд хүрэв. Үүнд:

- Манж, Богд хаант Монгол улсын үеийн газрын зураг нь манай орны соёл-түүхийн нэгэн чухал өв мөн бөгөөд түүнийг анхааралтай судлах цаг нэгэнт болжээ.
- Түүхэн өмнөх үед монголчууд газрын зургийг дараах гурван аргаар үйлдэж байжээ. Үүнд:
  - Хошууны нутгийн өмнөд болон хойд этгээдээс нь нийт нутаг дэвсгэрийг тоймлох;
  - Хошууны нутгийн төвөөс тал бүрт тойруулан нийт нутаг дэвсгэрийг тоймлох;
  - Хошууны нийт нутгийг тойрон явж, нутгийн төв рүү хандах чиглэлээр тус тус тоймлох явдал болно.
- Судалгаанд хамруулсан нийт 74 газрын зурагт тэмдэглэгдсэн дэвсгэр нэр болон оноосон гишүүний тоо, төрөл зүйл, тэмдэглээг нарийвчлан тогтоож тодорхой жишээгээр нотлов.



- Бира Ш.** Их Монгол улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд, УБ., 2006
- Гончигдорж Б.** Монголчуудын газарзүйн зургийн түүхийн зарим асуудал – “Шинжлэх Ухаан Академийн Мэдээ”, УБ., 1970, №1
- (ДТМГНН)** Дэлхийд тархсан Монгол газар нутгийн нэр(Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан), УБ., 2005
- Равдан Э.** “Монгол газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа” УБ., 2004
- Равдан Э.** “Монгол газар нутгийн нэрзүй” УБ., (гар бичмэл)
- Салишеев К. А.** “Картоведение” Издательство Московского университета 1982, 18-21, 311-313
- Шагдарсүрэн Ц.** “Монголчуудын утга соёлын товчоон”, УБ., 2003
- Эрдэнэцэцэг Д.** “Зурагзүйн хангамж ба их дээд сургуульд зориулагдсан сери зургийн зохиолтын аргазүйн асуудал” УБ., 2000 (докторын диссертаци)
- H. Futaki, K. Akira,** Landscaps Reflected in Old Mongolian maps, Tokio, 2005
- Hedin Sven.** Central Asia Atlas. Etnografiska museet, The Sino-Swedish expedition, “Reports from the scientific expedition to the north-western provinces of China under leadership of DR. Sven Hedin”, publication –47, Stockholm, 1969
- Memoir on maps.vol. 1, Records on Surveys, by Ambolt N. P. and E. Norin,** publication – 48, “Reports from the scientific expedition to the north-western provinces of China under leadership of DR. Sven Hedin”, Stockholm,
- Index of Geographical Names / vol. 2/ by Farquhar D.M. Jarring G.** publication –50  
“Reports from the scientific expedition to the north-western provinces of China under leadership of DR. Sven Hedin”, Stockholm,
- Heissig W.** unter Mitarbeit von K.Sagaster, Mongolische Handschriften. Blockdrucke. Landkarten Verzeichnis der orientalischen Handschriften in Deutschland, Bd. 1, Weisbaden, (1978, 14):
- Heissig W.** Mongolische Ortsnamen, Aus Mongolischen Manuskript-Karten, Weisbaden, 1966, teil 1) 217p
- Heissig W.** (Mongolische Ortsnamen, Mongolischen Manuskriptkarten in faksimilia, Weisbaden, 1978, teil 2,) ,688 p

**Heissig W.** Mongolische Ortsnamen, Planquadratzahlen und Namensgruppierungen, Weisbaden, 1981, teil 3) 207p

**Jarring G.** Some Notes on Central Asian Turkic Place Names, Bulletin of the geological institutions of the University Uppsala, vol XL, 1961, 467-478

**Толь бичгүүд**

(Britanica, v. 23, 473-494) The New Encyclopedia Britanica, 15 th edition. v. 23, 1985

(World book, v.13, 177-185), The World Book Encyclopedia, v.13, 1994

Монгол газар нутгийн нэргийн зүйлчилсэн толь (Манж, Богд хаант Монгол улсын үе, хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан) УБ., 2004 он.

**ABSTRACT**

The article is aimed to introduce the mapping tradition implied to the period of the Manju oppressed and Bogd Monarchy Mongolia, to observe its peculiarities and to establish the basic toponyms marking natural objects. The research is followed by the outcomes underneath:

- The map of the Manju oppressed and Bogd Monarchy Mongolia presents a valuable cultural and historical heritage of the country and pressing studies on it is required urgently.
- Previously the Mongols compiled maps in the following three ways:
  - A whole provincial territory is observed both from the South and the North.
  - A whole provincial territory is observed from the center to all directions around in circle.
  - An observation is made as a whole provincial territory is round tripped followed by the trips to the center.
- All the 74 maps being analyzed are defined in the both basic toponyms and proper names by their numbers, diversities and detailed markings and particular examples have been attached for an illustration.